ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/63/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Орхон аймаг<br>2021 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах<br>Утас:70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Эрдэнэ<br>Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br>Аудитор: Т.Болормаа<br>Утас: 70357955 Цахим хаяг:bolormaat@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....11
3. Аудитын тайлан....13
3.1. Ерөнхий зүйл....13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....14
3.4. Материаллаг байдал ....14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....16
3.7. Шилэн дансны мэдээлэл ....17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....17
3.9. Аудитын илрүүлэлт....17
Залруулсан алдаа....17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....17
Аудитын зөвлөмж....20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....20
4. Менежментийн захидал....20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....22

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn
2021.02.25 № 71
танай ______ -ны № ______ -т

ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

D:\my doc \albanbichig\ 2021-A4.doc

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **522,470,812.30** | **625,050,894.46** |
| **33** | **АВЛАГА** | 400,000.00 | 23,500,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 400,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | - | 23,500,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 23,500,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 522,070,812.30 | 601,550,894.46 |
| **351** | **Түүхий эд материал** | 456,507,235.90 | 472,576,341.06 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 456,507,235.90 | 472,576,341.06 |
| **354** | **Хангамжийн материал** | 65,563,576.40 | 128,974,553.40 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 18,660,601.00 | 13,305,051.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 20,470,486.40 | 30,328,256.40 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 4,856,800.00 | 560,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 77,889.00 | 691,446.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 7,418,000.00 | 46,605,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 14,079,800.00 | 37,484,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,922,320,134.79** | **5,867,077,352.78** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 5,922,320,134.79 | 5,867,077,352.78 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,272,163,075.37 | 4,219,335,664.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,177,559,702.48 | 3,183,059,702.48 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (88,400,193.31) | (169,727,826.97) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 874,921,532.60 | 759,033,332.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (560,281,306.29) | (384,281,293.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,280,810,746.49 | 1,490,714,078.84 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (669,715,286.59) | (870,027,348.92) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 693,552,532.07 | 698,764,232.07 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (436,284,652.08) | (488,199,212.87) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,650,157,059.42 | 1,647,741,688.55 |
| 39301 | Програм хангамж | 243,199,000.00 | 285,999,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (126,001,940.58) | (171,217,311.45) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,532,960,000.00 | 1,532,960,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **6,444,790,947.09** | **6,492,128,247.24** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **4,519,503.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 4,519,503.00 | - |
| **413** | **Өглөг** | 4,519,503.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 4,519,503.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,440,271,444.09** | **6,492,128,247.24** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,440,271,444.09 | 6,492,128,247.24 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,643,523,998.91 | 3,643,523,998.91 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,110,563,998.91 | 2,110,563,998.91 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 677,193,271.39 | 729,050,074.54 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 677,193,271.39 | 677,193,271.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 51,856,803.15 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,119,554,173.79 | 2,119,554,173.79 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **6,444,790,947.09** | **6,492,128,247.24** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,400,047,239.50** | **4,093,157,266.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **608,493,676.00** | **732,329,565.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 608,493,676.00 | 732,329,565.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 608,493,676.00 | 732,329,565.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,456,290.00 | 5,038,500.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 604,037,386.00 | 727,291,065.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,791,553,563.50** | **3,360,827,701.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 597,774,063.50 | 797,606,601.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 637,562,880.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 449,157,581.00 | 70,145,628.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 148,616,482.50 | 89,898,093.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,193,779,500.00 | 2,563,221,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,193,779,500.00 | 2,563,221,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,682,605,218.92** | **4,003,408,238.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,682,605,218.92** | **4,003,408,238.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,528,692,495.42 | 3,809,441,814.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 938,971,363.24 | 1,145,547,641.00 |
| 210101 | Үндсэн цалин | 755,452,763.64 | 844,348,445.40 |
| 210102 | Нэмэгдэл | 700,000.00 | - |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 52,294,514.78 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 182,818,599.60 | 248,904,680.82 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 124,852,403.00 | 124,861,542.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 80,035,692.00 | 88,293,814.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,394,411.00 | 9,029,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,349,000.00 | 7,255,503.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,710,800.00 | 1,287,696.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,362,500.00 | 18,994,727.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 58,294,882.00 | 62,832,077.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,957,751.00 | 22,257,356.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,719,139.00 | 29,653,058.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,617,992.00 | 10,921,663.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 131,123,574.49 | 154,724,998.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 32,885,260.00 | 51,411,532.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 71,777,140.49 | 61,444,207.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,980,345.00 | 15,864,509.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,620,550.00 | 2,764,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 8,808,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,860,279.00 | 14,432,750.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,222,170.00 | 21,781,070.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,394,270.00 | 6,206,070.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,827,900.00 | 15,575,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 143,204,547.00 | 119,625,875.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,404,750.00 | 23,300,000.00 |
| 210602 | Тавилга | 9,119,800.00 | 22,700,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 83,679,997.00 | 73,625,875.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 335,717,116.00 | 100,614,517.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 57,039,532.00 | 38,176,797.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 278,677,584.00 | 62,437,720.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 653,532,005.00 | 580,300,751.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 627,175,980.00 | 538,396,651.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 1,752,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13,417,000.00 | 13,417,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,270,225.00 | 1,350,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 319,000.00 | 315,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 283,800.00 | 10,320,900.00 |
| 210807 | Газрын төлбөр | 9,866,000.00 | 14,749,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,121,774,434.69 | 1,499,153,342.47 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 588,181,630.80 | 935,946,557.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 46,851,140.00 | 76,945,375.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 486,741,663.89 | 486,261,410.47 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 153,912,723.50 | 193,966,424.05 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 113,828,644.00 | 135,721,800.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 20,000,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 21,192,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 93,828,644.00 | 114,529,300.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 40,084,079.50 | 4,354,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 40,084,079.50 | 4,354,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 53,890,624.05 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 53,890,624.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(282,557,979.42)** | **89,749,027.53** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 29,888,465.07 | 37,892,224.38 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 29,888,465.07 | 37,892,224.38 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (29,888,465.07) | (37,892,224.38) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(312,446,444.49)** | **51,856,803.15** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,796,009,853.50** | **3,389,366,201.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,456,290.00** | **5,038,500.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,456,290.00 | 5,038,500.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,456,290.00 | 5,038,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,456,290.00 | 5,038,500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,791,553,563.50** | **3,384,327,701.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 597,774,063.50 | 821,106,601.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 661,062,880.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 449,157,581.00 | 70,145,628.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 148,616,482.50 | 89,898,093.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 2,193,779,500.00 | 2,563,221,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 2,193,779,500.00 | 2,563,221,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,750,492,553.50** | **3,314,195,101.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,750,492,553.50** | **3,314,195,101.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,596,579,830.00** | **3,095,101,304.95** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 924,313,300.00 | 1,150,067,144.00 |
| 210101 | Үндсэн цалин | 731,634,585.54 | 844,348,445.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 10,625,475.00 | 52,294,514.78 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 182,053,239.46 | 253,424,183.82 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 124,852,403.00 | 124,861,542.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,879,903.00 | 88,293,814.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,243,100.00 | 9,029,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,394,500.00 | 7,255,503.91 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,972,400.00 | 1,287,696.09 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,362,500.00 | 18,994,727.74 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 58,294,882.00 | 62,832,077.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,957,751.00 | 22,257,356.00 |
| 210302 | Түлш, халаалт | 28,719,139.00 | 29,653,058.11 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,617,992.00 | 10,921,663.20 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 131,469,958.00 | 137,827,068.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 31,277,121.00 | 40,720,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 70,595,442.00 | 56,853,809.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 14,980,345.00 | 15,886,509.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 9,510,500.00 | 835,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 8,808,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,106,550.00 | 14,723,350.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,189,129.00 | 21,946,840.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,433,149.00 | 6,206,070.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,755,980.00 | 15,740,770.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 157,712,479.00 | 171,954,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 69,892,012.00 | 37,142,380.00 |
| 210602 | Тавилга | 9,183,600.00 | 36,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 78,636,867.00 | 98,311,820.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 328,933,454.00 | 93,293,517.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 57,039,532.00 | 38,176,797.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 271,893,922.00 | 55,116,720.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 460,596,005.00 | 556,395,250.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 429,546,980.00 | 516,672,650.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,200,000.00 | 1,752,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 13,417,000.00 | 13,417,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,270,225.00 | 1,350,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 319,000.00 | 315,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,976,800.00 | 8,139,400.00 |
| 210807 | Газрын төлбөр | 9,866,000.00 | 14,749,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 383,218,220.00 | 775,923,666.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 326,809,080.00 | 689,257,091.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 56,409,140.00 | 86,666,575.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **153,912,723.50** | **219,093,796.05** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 113,828,644.00 | 137,349,172.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 20,000,000.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 21,192,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 93,828,644.00 | 116,156,672.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 14,250,535.00 | 4,354,000.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,250,535.00 | 4,354,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 25,833,544.50 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,833,544.50 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 77,390,624.05 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 77,390,624.05 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **45,517,300.00** | **75,171,100.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **45,517,300.00** | **75,171,100.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **45,517,300.00** | **75,171,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 45,517,300.00 | 75,171,100.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 45,517,300.00 | 75,171,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(45,517,300.00)** | **(75,171,100.00)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | - | - | - | - |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,643,523,998.91** | **2,119,554,173.79** | **677,193,271.39** | 6,440,271,444.09 |
| **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,643,523,998.91** | **2,119,554,173.79** | **677,193,271.39** | 6,440,271,444.09 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,643,523,998.91** | **2,119,554,173.79** | **677,193,271.39** | 6,440,271,444.09 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 51,856,803.15 | 51,856,803.15 |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,643,523,998.91** | **2,119,554,173.79** | **729,050,074.54** | 6,492,128,247.24 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03/134 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар Орхон аймгийн ЗДТГ-ны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

33.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 33.1.1.харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах;
- 33.1.2.Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах;
- 33.1.3.Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- 33.1.4.хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- 33.1.5.Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- 33.1.6.төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- 33.1.7.тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг хангаж аж ахуйн талаар үйлчлэх.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, нийт 472.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5 зөвлөмж өгсөн байна.

2020 оны 07 дугаар сард 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаа болон өмнөх шалгалтын зөвлөмжийн биелэлтийн талаар хянаж нийт биелэлтийн 55% нь хэрэгжиж, 45% нь биелээгүй гэж үзэн аудитын дүнгээр “Сайжруулах шаардлагатай буюу хангалттай бус” санал дүгнэлт өгсөн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 2,174,283.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 21,742.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 4,116,657.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 41,166.6 мянган төгрөг болгон өөрчилсөн.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,337.3 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 400.00 | 23,500.00 | 23,100.00 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 522,070.80 | 601,550.90 | 79,480.10 |
| Үндсэн хөрөнгө | 5,922,320.10 | 5,867,077.40 | -55,242.70 |
| Нийт хөрөнгө | 6,444,790.90 | 6,492,128.20 | 47,337.30 |
| Өр төлбөр | 4,519.50 | - | -4,519.50 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 2,110,563.90 | 2,110,563.90 | - |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 6,444,790.90 | 6,492,128.20 | 47,337.30 |

Авлага дансны үлдэгдэл 23,500.0 мянган төгрөг болж 23,100.0 мянган төгрөгөөр өссөн нь Засаг даргын нөөц хөрөнгийн 210901 ангиллаас оны эцэст 23,500.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлж, түүнийгээ авлагаар бүртгэснээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 601,550.9 мянган төгрөг болж 79,480.1 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын бараа материал өмнөх оноос 16,069.1 мянга, аж ахуйн материал 9,857.8 мянга, барилгын засварын материал 39,187.0 мянга, бусад хангамжийн материал 23,405.0 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй 22,367.3 мянган төгрөгийн ном хэвлэл, гарын авлага, жуух бичгийн хавтас, тэмдэгний үнэмлэх 8,896.4 мянган төгрөг тусгай зориулалтын бараа материалд бүртгэлтэй байна.

Энэ нь он удаан жил хадгалснаар ашиглалтын шаардлага хангахаа болих, хэрэгцээ шаардлага хангахгүй хуучрах үр дагавартай байна.

Оны эцэст буюу 12 сард 69,595.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь төсвийн хэмнэлтийг төвлөрүүлэхгүй зарцуулах, ашиглалтгүй бараа материал бэлтгэх үр дагавартай байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,867,077.4 мянган төгрөг болж 55,242.7 мянган төгрөгөөр буурсан нь 488,260.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, 340,734.0 мянган төгрөгөөр хасагдаж, тайлант оны хуримтлагдсан элэгдэл 486,261.4 мянган төгрөгийг хүлээн зөвшөөрснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 278,589.7 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 75,171.1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 134,500.0 мянган төгрөг, нийт 488,260.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 49,000.0 мянган төгрөг, акталсан 291,734.0 мянган төгрөг нийт 340,734.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө буюу программ хангамжийн эхний үлдэгдэл 243,199.0 мянган төгрөг тайлант онд 49,500.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 6,700.0 мянган төгрөгийн программыг акталж, 285,999.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 4,519.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд үүссэн ХАОАТ-ын өглөгийг бүрэн төлснөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,110,563.9 мянган төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Орхон аймгийн ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 692,197.2 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого 120,786.1 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 123,253.7 мянга, нэмэлт санхүүжилтийн орлого 203,332.5 мянга, урсгал санхүүжилт 369,441.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 344,303.0 мянган төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, хангамжийн бараа материал, тэтгэмжийн зардлууд байна.

## 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,956,222.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,956,222.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,392,950.9 мянган төгрөгөөр бууруулж 2,563,271.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлттэй нь хангамж, бараа материал 226,067.8 мянга, эд хогшил худалдан авах зардал 135,566.7 мянга, томилолт 318,555.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 195,327.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,563,271.1 мянган төгрөгийн төсөв батлснаас 2,563,271.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,563,221.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 5,038.5 мянган төгрөг, нийт 2,568,259.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,514,368.9 мянган төгрөгийг зарцуулж 53,890.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,514,368.9 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 20,508.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 17,331.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,380.3 мянган төгрөгөөр, томилолтын зардлыг 6,220.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сангаас 220,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 397,562.9 мянга, архивын ерөнхий газраас 18,197.1 мянга, цэргийн дүйцүүлэх албаны орлого 89,898.1 мянга, бусад яамнаас 48,124.6 мянга, ЗГХЭГ-аас 20,000.0 мянга, Төрийн албаны зөвлөлөөс 3,824.0 мянга нийт 797,606.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 24,373.1 мянга, томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 11,104.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 427,057.8 мянга, хангамж, бараа материалд 17,274.2 мянга, нормативт зардалд 9,206.1 мянга, эд хогшил худалдан авах 23,379.5 мянга, тэтгэмжид 13,200.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 228,657.5 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 39,000.0 мянган төгрөг, нийт 793,252.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,354.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 131 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 16 мэдээлэл, 24 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллээс үзэхэд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 41 орлогын гүйлгээ, 71 зарлагын гүйлгээ нийт 112 гүйлгээнээс  25 гүйлгээг мэдээлж, 87 гүйлгээг мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3,480.0 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн актыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 28,570.0 мянган төгрөгийн 6 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3*  Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 3 | 3.48 | 3 | 3.48 | - | - | |
| Албан шаардлага | - | - | - | - | | | |
| Зөвлөмж | 6 | 28.57 | 6 | 28,57 | - | - | |
| Нийт дүн | 9 | 32.05 | 9 | 32.05 | - | - | |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 67,574.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 23,500.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,439.2 мянган төгрөгийн зөрчилд 3 акт тогтоож, 24,689.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 12,945.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн харилцах данснаас засаг даргын нөөц хөрөнгийн хэмнэлт 23,500.0 мянган төгрөгийг нэмэлт дансанд шилжүүлж оны эцэст төвлөрүүлсэн бөгөөд түүнийг орлого үр дүнгийн тайланд давхар орлогоор хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 31,128.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 6,439.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 24,689.4 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.Үүнд:

1. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны тушаал шийдвэргүй аймгийн ЗДТГ-ын дарга нь 2020 оны 1,2,3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 1,392.3 мянга, аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүүг 3 сарын хугацаагаар албан тушаалаас нь түр түдгэлзүүлсэн байтал аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар 2020 оны 04 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал 464.1 мянга, нийт 1,856.4 мянган төгрөгийг бодож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1-т “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид заалттай нийцэхгүй, иж бүрэн, тохилдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

2. Ахлах нягтлан бодогч Л.Дуламжав нь эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 2020 оны 07 сард үндсэн цалингийн 40% урамшуулал 319.1 мянган төгрөг, ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан алба хаагчдад үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгоход өөртөө 1 сарын цалингаар бодож 478.6 мянган төгрөг, цалингаас нийт 797.7 мянган төгрөгийг илүү тооцож авсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т “ хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих”, 20.2.13-т “эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

   Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

3. Аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/137 дугаар тушаалаар ээлжийн амралттай байх хугацаандаа албан ажлын зайлшгүй шаардлагаар ажилдаа дуудагдан орж ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй алба хаагч нарт цалинг 0.5% дахин нэмэгдүүлж өгсөн. Харин дээрх тушаалд нэр дурдагдсан алба хаагчдаас түүвэрлэн үзэхэд ээлжийн амралттай байх хугацаанд цалинг давхардуулан 3,785.4 мянган төгрөг олгосон байна. Үүнд:

   - Аймгийн ЗДТГ-ын дарга 2020 оны 02 дугаар сард ажлын 17 хоног бүтэн ажиллан, амралтын нөхөн олговрыг 02 сарын цалинтай хамт авч ажлын 20 хоног амрах байтал 2020 оны 03 сард ажлын 2 хоногийн цалин бодогдох ёстой байхад 22 хоног бүтэн ажилласнаар тооцон 20 хоногийн 1,408.1 мянган төгрөгийн цалинг илүү тооцож өгсөн.
   - Цэргийн штабын дарга Б.Оюунтүлхүүр 2020 оны 07 сард 20 хоног ажиллахаас 11 хоног ажиллаад ээлжийн амралтын 27 хоногийн нөхөн олговор аваад амарсан байхад дараа сард 3 хоногийн цалин олгох байтал бүтэн ажилласнаар цалин олгож 18 хоногийн цалин 1,676.8 мянган төгрөг илүү олгосон.
   - Цэргийн штабын дайчилгааны офицер Б.Бат-Эрдэнэ 9 сард ээлжийн амралтын нөхөн олговор аваад ажлын 24 хоног амрах ёстой байхад 10 сард 2 хоногийн цалин дутуу бодогдох байтал бүтэн ажилласнаар тооцож 2 хоногийн 97.9 мянган төгрөгийн цалин илүү олгосон.
   - Цэргийн штабын дайчилгааны офицер Ч.Энхбаяр нь 6 сард бүтэн ажиллаж ээлжийн амралтаа авсан бөгөөд нийт ажлын 27 хоног амрах ёстойгоос 7

сарын ажлын 20 хоногт бүтэн амраад 8 сард 7 хоног амарч цалин дутуу бодогдох ёстой байтал ажлын 21 хоног бүтэн ажилласнаар тооцож 7 хоногийн 602.6 мянган төгрөг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ" заалттай нийцэхгүй, иж бүрэн байдал, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоов.

4. Аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэгдсэн СТСХ-ийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, ЗДТГ-ын нягтлан бодогч нарт үндсэн цалингийн 40% тэнцэх хэмжээний буюу 1,095.9 мянган төгрөг олгосон нь улирал бүр хийсэн ажлаа дүгнүүлэн үр дүнгийн урамшуулал, төрийн үйлчилгээний алба хаагч сар бүр 25%-ийн ур чадварын нэмэгдэл авч байхад урамшууллыг давхардуулан олгосон. Мөн ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн А/72 дугаар тушаалаар 2019 оны ажлын үр дүнгээр МУ-ын шилдэг аймгаар шалгарсантай холбогдуулан идэвх зүтгэлтэй ажилласан алба хаагч нарт цалингийн зардлаас урамшуулал олгохдоо 18 алба хаагчдад 40 хувиас хэтрүүлэн 9,980.6 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага хүргүүлэв.

5. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолтын зардал олголт, түүний баримтын бүрдэл нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийн шаардлагыг бүрэн хангахгүй байх тул албан томилолтын зардлын зарцуулалтад хяналт тавьж, баримт материалыг журмын дагуу бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, тайлант онд 5,432.0 мянган төгрөгийг томилолтын тооцооны хуудсыг томилолтоор ажилласан газрын албан байгууллагаар баталгаажуулаагүй байхад олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.
Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага хүргүүлэв.

6. Цалингийн зардлын хэмнэлтээс аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар 2020 оны үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамт олноо тэргүүлэн ажилласан 2 албан хаагчид үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, 6 албан хаагчид нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 8,180.9 мянган төгрөгийн мөнгөн шагналаар

шагнаж, цалингийн зардлаас олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 210101-Үндсэн цалин нь “Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана”, 210102-нэмэгдэлд “Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд .....”гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Албан шаардлага хүргүүлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 12,945.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Орхон аймгийн ЗДТГ-ын шатахууны зардал, бараа материалын анхан шатны баримтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1.Зардлын данстай холбоотой асуудал*

*1.1.* *Илрүүлэлт:* Тайлант онд багаж техник хэрэгслийн 210601- зардлаас 35,920.0 мянган төгрөгөөр зочдын бэлэг дурсгалын зүйл /зэс домбо, мөнгөн аяга, уран зураг/ худалдан авсан, тавилга эд хогшил 210602- ангиллын зардлаас 34,805.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын мөнгөн аяга, уут авсан, мэдээлэл, технологийн үйлчилгээ 210806-зардлын ангиллаас 1,807.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 210902-зардлаас зочид буудлын төлбөр 6,000.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан нь зардлын бүлэн хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан Эдийн засгийн ангилалтай нийцэхгүй байна.

*1.2.* *Эрсдэл:* Ашиг сонирхол үүсэх, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх

*1.3.* *Өгсөн зөвлөмж*: Эдийн засгийн ангиллын дагуу гүйлгээг хийж, хянаж байх.

*1.4.* *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03/686 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

*2.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл*

*2.1. Илрүүлэлт:* Харилцах дансны хуулгаас үзэхэд үндсэн болон нэмэлт данснаас Ник ХХК-д 28,295.9 мянга, Петростар ХХК-д 42,474.6 мянган нийт 70,770.5 мянган төгрөгийн

шатахууны үнэ шилжүүлсэн байтал БМ-ын тодруулга тайланд 57,825.4 мянган төгрөгийн

Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

шатахууныг орлого авч 12,945.1 мянган төгрөгийг шатахууныг орлогод тусгаагүй шууд зардалд бүртгэсэн байна.

*2.2. Эрсдэл:* Ашиглал үүсэх, харилцагч байгууллага тайлан бүртгэлд тусгаагүй байх.

*2.3. Өгсөн зөвлөмж:* Байгууллагын данснаас шилжүүлсэн бараа материалд бүртгэлд тусгасны дараа бусад байгууллагад шилжүүлснээр бүртгэж байх.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03/686 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

*3.Шилэн данстай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Шилэн дансны сайтад байршуулсан мэдээллийг харилцах дансны хуулгатай тулгахад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээнээс нийт 112 мэдээллийг байршуулахаас 25 мэдээллийг байршуулж, 87 гүйлгээг мэдээлээгүй байна.

*3.2. Эрсдэл:* хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

*3.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасны дагуу цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр бүрэн мэдээлж байх.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03/686 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР: Т.БОЛОРМАА

ОРА-**2021/63/СТА-ТШЗ** 12

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2021 | | | ОРА-2021/63/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | **Орхон аймгийн ЗДТГ** | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Эрх бүхий байгууллага, албан тушаалтны тушаал шийдвэргүй аймгийн ЗДТГ-ын дарга нь 2020 оны 1,2,3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 1,392.3 мянга, аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүүг 3 сарын хугацаагаар албан тушаалаас нь түр түдгэлзүүлсэн байтал аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар 2020 оны 04 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал 464.1 мянга, нийт 1,856.4 мянган төгрөгийг бодож олгосон. | 1,856.4 | Төлбөрийн акт | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |
| 2 | Ахлах нягтлан бодогч Л.Дуламжав нь эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 2020 оны 07 сард үндсэн цалингийн 40% урамшуулал 319.1 мянган төгрөг, ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан алба хаагчдад үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгоход өөртөө 1 сарын цалингаар бодож 478.6 мянган төгрөг, цалингаас нийт 797.7 мянган төгрөгийг илүү тооцож авсан | 797.7 | Төлбөрийн акт | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |
| 3 | Аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/137 дугаар тушаалаар ээлжийн амралттай байх хугацаандаа албан ажлын зайлшгүй шаардлагаар ажилдаа дуудаган орж ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй алба хаагч нарт цалинг 0.5% дахин нэмэгдүүлж өгсөн. Харин дээрх тушаалд нэр дурдагдсан алба хаагчдаас түүвэрлэн үзэхэд ээлжийн амралттай байх хугацаанд цалинг давхардуулан 3,785.4 мянган төгрөг олгосон | 3,785.4 | Төлбөрийн акт | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |
| | Аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэгдсэн СТСХ-ийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, ЗДТГ-ын нягтлан бодогч нарт үндсэн цалингийн 40% тэнцэх хэмжээний буюу 1,095.9 мянган төгрөг олгосон нь улирал бүр хийсэн ажлаа дүгнүүлэн үр дүнгийн урамшуулал, төрийн үйлчилгээний алба хаагч сар бүр 25%-ийн ур чадварын нэмэгдэл авч байхад урамшууллыг давхардуулан олгосон. Мөн ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн А/72 дугаар тушаалаар 2019 оны ажлын үр дүнгээр МУ-ын шилдэг аймгаар шалгарсантай холбогдуулан идэвх зүтгэлтэй ажилласан алба хаагч нарт цалингийн зардлаас урамшуулал олгохдоо 18 алба хаагчдад 40 хувиас хэтрүүлэн 9,980.6 мянган төгрөг олгосон. | 11,076.5 | Албан шаардлага | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |
| 5 | Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолтын зардал олголт, түүний баримтын бүрдэл нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийн шаардлагыг бүрэн хангахгүй байх тул албан томилолтын зардлын зарцуулалтад хяналт тавьж, баримт материалыг журмын дагуу бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, тайлант онд 5,432.0 мянган төгрөгийг томилолтын тооцооны хуудсыг томилолтоор ажилласан газрын албан байгууллагаар баталгаажуулаагүй байхад олгосон. | 5,432.0 | Албан шаардлага | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |
| 6 | Цалингийн зардлын хэмнэлтээс аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар 2020 оны үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамт олноо тэргүүлэн ажилласан 2 албан хаагчид үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, 6 албан хаагчид нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 8,180.9 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж, цалингийн зардлаас олгосон | 8,180.9 | Албан шаардлага | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |
| 7 | Тайлант онд багаж техник хэрэгслийн 210601- зардлаас 35,920.0 мянган төгрөгөөр зочдын бэлэг дурсгалын зүйл /зэс домбо, мөнгөн аяга, уран зураг/ худалдан авсан, тавилга эд хогшил 210602-ангиллын зардлаас 34,805.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын мөнгөн аяга, уут авсан, мэдээлэл, технологийн үйлчилгээ 210806-зардлын ангиллаас 1,807.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 210902-зардлаас зочид буудлын төлбөр 6,000.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан. | | Зөвлөмж | ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч | Д.Соёлчхүү, Л.Дуламжав |

Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

шатахууныг орлого авч 12,945.1 мянган төгрөгийг шатахууныг орлогод тусгаагүй шууд зардалд бүртгэсэн байна.

*2.2. Эрсдэл:* Ашиглал үүсэх, харилцагч байгууллага тайлан бүртгэлд тусгаагүй байх.

*2.3. Өгсөн зөвлөмж:* Байгууллагын данснаас шилжүүлсэн бараа материалд бүртгэлд тусгасны дараа бусад байгууллагад шилжүүлснээр бүртгэж байх.

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03/686 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

*3.Шилэн данстай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Шилэн дансны сайтад байршуулсан мэдээллийг харилцах дансны хуулгатай тулгахад 5 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээнээс нийт 112 мэдээллийг байршуулахаас 25 мэдээллийг байршуулж, 87 гүйлгээг мэдээлээгүй байна.

*3.2. Эрсдэл:* хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

*3.3. Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасны дагуу цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр бүрэн мэдээлж байх.

*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Орхон аймгийн ЗДТГ-ын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 03/686 дугаарын албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР: Т.БОЛОРМАА

**ОРХОН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 25 өдөр        Дугаар 78/78 ОДА-2021/63/СТА-ТШ3        Эрдэнэт

## ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэгдсэн СТСХ-ийн дарга, төсвийн ерөнхий нягтлан бодогч, ЗДТГ-ын нягтлан бодогч нарт үндсэн цалингийн 40% тэнцэх хэмжээний буюу 1,095.9 мянган төгрөг олгосон нь улирал бүр хийсэн ажлаа дүгнүүлэн үр дүнгийн урамшуулал, төрийн үйлчилгээний алба хаагч сар бүр 25%-ийн үр чадварын нэмэгдэл авч байхад урамшууллыг давхардуулан олгосон.

2. ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн А/72 дугаар тушаалаар 2019 оны ажлын үр дүнгээр МУ-ын шилдэг аймгаар шалгарсантай холбогдуулан идэвх зүтгэлтэй ажилласан алба хаагч нарт цалингийн зардлаас урамшуулал олгохдоо 18 алба хаагчдад 40 хувиас хэтрүүлэн 9,980.6 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн алба хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2-т ”Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар

тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бус зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Алба хаагчдад цалингийн зардлаас 11,076.5 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, нягтлан бодогч Л.Дуламжав нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:..................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН МЕНЕЖЕР..................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..................................Т.БОЛОРМАА

**ОРХОН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 79/79 ОАГ-2021/63/СТА-ТШЗ Эрдэнэт

## ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлын хэмнэлтээс аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар 2020 оны үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр хамт олноо тэргүүлэн ажилласан 2 албан хаагчид үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, 6 албан хаагчид нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний нийт 8,180.9 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж, цалингийн зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” 210101-Үндсэн цалин нь “Цалингийн сүлжээ болон бусад холбогдох эрх зүйн актын дагуу тогтоон олгож байгаа албан тушаалын үндсэн цалин энэ ангилалд багтана”, 210102-нэмэгдэлд “Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу олгож байгаа нэмэгдэл цалингууд .....” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн зардлын хэмнэлтээс шагнал урамшуулал олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, нягтлан бодогч Л.Дуламжав нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:..................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..................................Т.БОЛОРМАА

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 80/80 ОРА-2021/63/СТА-ТШЗ Эрдэнэт

## ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан томилолтын зардал олголт, түүний баримтын бүрдэл нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрийн шаардлагыг бүрэн хангахгүй байх тул албан томилолтын зардлын зарцуулалтад хяналт тавьж, баримт материалыг журмын дагуу бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй, тайлант онд 5,432.0 мянган төгрөгийг томилолтын тооцооны хуудсыг томилолтоор ажилласан газрын албан байгууллагаар баталгаажуулаагүй байхад олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын

4.2.1.10-д "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Томилолтын тооцоог олгохдоо анхан шатны баримтын бүрдэл хангаагүй олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, нягтлан бодогч Л.Дуламжав нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:....................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР....................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР....................................Т.БОЛОРМАА

Акт:

**ОРХОН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2021 оны 02 сарын 25 өдөр          Дугаар 41/41 ОРА-2021/63/ СТА-ТШЗ          Эрдэнэт хот

**ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллага, албан тушаалтны тушаал шийдвэргүй аймгийн ЗДТГ-ын дарга нь 2020 оны 1,2,3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 1,392.3 мянга, аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүүг 3 сарын хугацаагаар албан тушаалаас нь түр түдгэлзүүлсэн байтал аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/142 дугаар тушаалаар 2020 оны 04 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал 464.1 мянга, нийт 1,856.4 мянган төгрөгийг бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1-т "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал

урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүүд эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулалд олгосон 1,856.4 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, нягтлан бодогч Л.Дуламжав нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.....................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.....................................Т.БОЛОРМАА

[1] Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2021 оны 02 сарын 25 өдөр　　Дугаар 43/43 ОДТ-2021/63/СТА-ТШЗ　　Эрдэнэт хот

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/137 дугаар тушаалаар ээлжийн амралттай байх хугацаандаа албан ажлын зайлшгүй шаардлагаар ажилдаа дуудагдан орж ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй алба хаагч нарт цалинг 0.5% дахин нэмэгдүүлж өгсөн. Харин дээрх тушаалд нэр дурдагдсан алба хаагчдаас түүвэрлэн үзэхэд ээлжийн амралттай байх хугацаанд цалинг давхардуулан 3,785.4 мянган төгрөг олгосон байна. Үүнд:

1. Аймгийн ЗДТГ-ын дарга 2020 оны 02 дугаар сард ажлын 17 хоног бүтэн ажиллан, амралтын нөхөн олговрыг 02 сарын цалинтай хамт авч ажлын 20 хоног амрах байтал 2020 оны 03 сард ажлын 2 хоногийн цалин бодогдох ёстой байхад 22 хоног бүтэн ажилласнаар тооцон 20 хоногийн 1,408.1 мянган төгрөгийн цалинг илүү тооцож өгсөн.
2. Цэргийн штабын дарга Б.Оюунтүлхүүр 2020 оны 07 сард 20 хоног ажиллахаас 11 хоног ажиллаад ээлжийн амралтын 27 хоногийн нөхөн олговор аваад амарсан байхад дараа сард 3 хоногийн цалин олгох байтал бүтэн ажилласнаар цалин олгож 18 хоногийн цалин 1,676.8 мянган төгрөг илүү олгосон.
3. Цэргийн штабын дайчилгааны офицер Б.Бат-Эрдэнэ 9 сард ээлжийн амралтын нөхөн олговор аваад ажлын 24 хоног амрах ёстой байхад 10 сард 2 хоногийн цалин дутуу бодогдох байтал бүтэн ажилласнаар тооцож 2 хоногийн 97.9 мянган төгрөгийн цалин илүү олгосон.
4. Цэргийн штабын дайчилгааны офицер Ч.Энхбаяр нь 6 сард бүтэн ажиллаж ээлжийн амралтаа авсан бөгөөд нийт ажлын 27 хоног амрах ёстойгоос 7 сарын ажлын 20 хоногт бүтэн амраад 8 сард 7 хоног амарч цалин дутуу бодогдох ёстой байтал ажлын 21 хоног бүтэн ажилласнаар тооцож 7 хоногийн 602.6 мянган төгрөг илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ээлжийн амралтын нөхөн олговор, цалинг давхардуулан олгосон 3,785.4 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, нягтлан бодогч Л.Дуламжав нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:...............................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР...............................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР...............................Т.БОЛОРМАА

[1] Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2021 оны 02 сарын 25 өдөр    Дугаар 42/42 ОА07-2021/63/СТА-ТШ3    Эрдэнэт хот

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн ЗДТГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ахлах нягтлан бодогч Л.Дуламжав нь эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй 2020 оны 07 сард үндсэн цалингийн 40% урамшуулал 319.1 мянган төгрөг, ЗДТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн А/70 дугаар тушаалаар 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт авсан алба хаагчдад үндсэн цалингийн 40%-тай тэнцэх мөнгөн урамшуулал олгоход өөртөө 1 сарын цалингаар бодож 478.6 мянган төгрөг, цалингаас нийт 797.7 мянган төгрөгийг илүү тооцож авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих", 20.2.13-т "эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ЗДТГ-ын нягтлан бодогч Л.Дуламжав өөртөө илүү тооцож авсан цалингийн нэмэгдэл 797.7 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн ЗДТГ-ын дарга Д.Соёлчхүү, нягтлан бодогч Л.Дуламжав нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.................................Т.БОЛОРМАА

[1] Монгол Улс, Орхон аймаг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-0757